ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ӨГӨГДӨЛ
/Хуульчийн мэргэжлийн шалгалтад оролцогч нарт зориулав/

Батбаяр нь 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдөр удаан уулзаагүй тул ганц шил архи ууя хэмээн дүү Тэгшээг ятгаж, түүний гэрт согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн. Шөнийн 00 цагийн үед дахин архи олж ир хэмээн уурлахад Тэгшээ айлын гэрт ирчхээд агсан тавилаа гээд хөлөөрөө түүний гуя хэсэгт хоёр удаа өшиглөж, хөлийнхөө улыг нүүрэнд нь тулгах зэргээр маргалдаж эхэлжээ. Улмаар Батбаяр “ахдаа хүндэтгэлгүй хандлаа” гэж орноос түлхэн гартаа барьж байсан хоосон архины шилээр Тэгшээгийн зүүн чамархай хэсэгт нэг удаа цохиход тэрээр цус алдаж эхэлсэн ба гэрээс гараад зугтаах гэхэд нь Батбаяр хойноос нь гүйцэж очоод гэр рүү чирч оруулан хөл, гар руу нь хэд хэдэн удаа цохисон байна. Тэгшээгийн найз Болд Батбаярт хандан болиоч гэхэд “та нар намайг барахгүй шүү, наадах чинь маргааш өглөө гэхэд үхээгүй байвал өөрөөр нь гэр цэвэрлүүлээрэй” гэж хэлэхэд Тэгшээ айж дахин гарч зугтжээ.

Тэгшээ гарч зугтаан 2022 оны 03 дугаар сарын 19-ний өглөө 05 цагийн үед гадаа осгож нас барсан байдалтай олдсон бөгөөд хэрэг бүртгэлтийн шатанд шинжээчийн дүгнэлтээр түүний биед “1. зүүн чамархайн хуйханд шарх, цус хуралт, зүүн чихний дэлбээ, их бие, мөчдөөр зулгаралтууд үүсчээ. 2. Дээрх гэмтлүүдээс зүүн чамархайн хуйхны шарх нь эрүүл мэндийг түр хугацаагаар сарниулах тул гэмтлийн зэрэг тогтоох журмын 2.4.1-т зааснаар гэмтлийн зэргийн хөнгөн зэрэгт хамаарна. Зүүн чихний дэлбээ, их бие мөчдийн зулгаралтууд тус тусдаа болон нийлээд эрүүл мэндийг сарниулахгүй тул гэмтлийн зэрэг тогтоох журмын 2.6-д зааснаар гэмтлийн зэрэгт хамаарахгүй гэмтлүүд болно. 4. Дээрх гэмтлүүд нь үхэлд хүргэхгүй. 5. Талийгаач нь нам хэвийн ерөнхий үйлчлэлээр осгож нас барсан” болох нь тогтоогдсон. Мөн шинжээч эмчээс “...архи уусан, их хэмжээний согтолттой байх нь цусны бүлэгнэл алдагдуулж, цус шингэрдэг тул цус алдалт үргэлжлэн явагдсан байж болно... Цус багадалттай тохиолдолд осголт амархан явагддаг. Талийгаач нь нас барах үедээ их хэмжээний согтолттой, ухамсарт ухаангүй болсон, хуйхны шархнаас гарсан цуснаас болж цус багадалтад орж, амархан осгож нас барсан байна... Осгохоос нь өмнө тусламжийг цаг хугацаанд нь тохируулж үзүүлсэн бол амь нас аврагдахыг үгүйсгэхгүй... Цус алдалт нь шоконд орох хэмжээний биш байсан... Хуйх бол хүний судасны цусан хангамж их байдаг. Тийм учраас хуйханд үүссэн шарх том жижгээс шалтгаалж цус гаралт бол бусад хэсгүүдтэй харьцуулахад их байдаг, архи уусан цус шингэрсэн байгаа тохиолдолд урсаж гардаг…” хэмээн мэдүүлжээ.

2025 оны 05 дугаар сарын 10-ны өдөр хэргийг анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэх шүүхийн хэлэлцүүлгийн явцад хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийн өмгөөлөгчөөс гаргасан хүсэлтээр шүүх хуралдааныг хойшлуулах шийдвэр гаргаж, шүүгч захирамжийг уншиж сонсгох үед Батбаяр бухимдаж, “миний саналыг үл хэрэгслээ” хэмээн прокурорыг зүй бус үгээр хараж, мөр рүү нь хоёр удаа гараараа цохижээ.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад мөрдөгч 2022 оны 03 дугаар сарын 19-ний өглөөний 06 цагийн орчимд Батбаярын согтолтын зэргийг тодорхойлох

зорилгоор хойшлуулшгүй тохиолдолд цусны дээж авах ажиллагааг түүний амаар өгсөн сайн дурын зөвшөөрлийн үндсэн дээр явуулсан боловч энэ талаар тэмдэглэлд тусгаагүй байна. Түүний өмгөөлөгчөөс хүний бие халдашгүй дархан байх тул уг ажиллагааг хууль бус гэж маргажээ. Харин хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөс оршуулгын зардалд 30,000,000 төгрөг, өмгөөллийн хөлс 5,000,000 төгрөг болон сэтгэцэд учирсан хор уршгийн нөхөн төлбөрийг хуульд заасан журмын дагуу гэм буруутай этгээдээс гаргуулах хүсэлтээ илэрхийлсэн ба төлбөрийн чадваргүй эсэх талаар баримтыг шүүхэд ирүүлээгүй байна.

Шийдвэрлэх асуудал: Бодлогын нөхцөлийн хүрээнд шийдвэрлэвэл зохих бүхий л асуудалд хууль зүйн дүгнэлт хийнэ үү.

Бодолт:

Нэг. Хууль зүйн дүгнэлт хийх хэм хэмжээг тодорхойлох

Бодлогын нөхцөлөөс үзэхэд Батбаяр хүний амь насыг хохироосон, мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг үйлдэл хийсэн байх тул Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10 болон 21 дүгээр бүлгээс тохирох хэм хэмжээг сонгож шалгана. Тодруулбал:

1.Батбаяр нь хохирогч Тэгшээгийн биед халдаж, амь насыг нь хохироосон үйлдлийн тухайд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.6 дугаар зүйлд заасан “Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох”;

2. Шүүх хуралдаанд оролцож байсан прокурорын биед халдаж цохисон үйлдэлд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.6 дугаар зүйлд заасан “Шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчид хууль бусаар нөлөөлөх” гэмт хэргийн шинжтэй эсэхийг шалгах нь зүйтэй байна.

Хоёр. Сонгон авсан хэм хэмжээ болон түүний хууль зүйн шинжийг тодорхойлж, бодлогын нөхцөлтэй субсумци хийх

Гэмт хэргийн шинж гэдэгт нийгэмд аюултай тодорхой үйлдлийг гэмт хэрэг гэж тодорхойлж буй Эрүүгийн хуульд заасан объектив болон субъектив шинжүүдийн нэгдлийг ойлгодог.

<u>2.1 Батбаяр нь бусдын амь насыг хохироосон үйлдлийн тухайд:</u>

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт, хэлцлээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл бусад болгоомжгүй үйлдлийн улмаас хүний амь насыг хохироосон” бол гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан. Энэ гэмт хэрэг нь гэмт этгээдийн болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүйн улмаас бусдын амь нас хохирсон, үйлдэл /эс үйлдэхүй/ ба үр дагаврын хооронд шалтгаант холбооны объектив хамааралтай байхыг шаарддаг материаллаг бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг мөн.

<u>Гэмт хэргийн объектив тал:</u> Хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт, хэлцлээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл бусад болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүй, үүний шууд үр дагаварт хүний амь нас хохирсон байна.

Бодлогын нөхцөлөөс харахад Батбаяр нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тухайн үед үүссэн хувийн таарамжгүй харилцааны улмаас хохирогч Тэгшээтэй маргалдсан, өөрийг нь өшиглөхөд бухимдаж түүний биед халдаж түлхэх, архины шилээр зүүн чамархай хэсэгт цохих, гар, хөл хэсэгт гараараа цохих зэрэг идэвхтэй үйлдлүүдээр гэмт хэрэг үйлдсэн байх ба шинжээчийн дүгнэлтээс шүүгдэгчийн үйлдлийн улмаас хохирогчийн зүүн чамархайд үүссэн хуйхны шарх гэмтэл, уг гэмтлийн улмаас цус алдаж цус багадалтад орсон үр дагаврыг шууд үүсгэсэн гэж дүгнэхээр байна.

Гэмт хэргийн шалтгаант холбооны объектив хамаарал гэдэг нь хуулийн дагуу хариуцлага хүлээх эрсдэлийг бий болгох, эсвэл эрсдэлийг нэмэгдүүлэх мөн эцсийн бий болсон үр дүнг хэрэгтэнд өөрт нь хамааруулах ойлголт юм. Батбаяр хохирогчийн эсрэг үргэлжилсэн халдлагыг хийгээгүй байсан бол хохирогч тухайн цаг хугацаанд шөнийн цагаар зугтаан гарч гадаа хонох нөхцөл үүсэхгүй ба шалтгаант холбоог тасалдуулах бусад хүчин зүйл байхгүй тул гэмт хэргийн объектив талын шинжийг хангасан гэж үзнэ.

<u>Гэмт хэргийн субъектив тал:</u> Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар гэмт этгээд “Өөрийн үйлдэл, эс үйлдэхүйг хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж түүний улмаас хохирол, хор уршиг учрах боломжтойг урьдчилан мэдэж түүнийг гаргахгүй байж чадна гэж тооцсон боловч хохирол, хор уршиг учирсан, эсхүл хохирол, хор уршиг учрах боломжтойг урьдчилан мэдэх ёстой, мэдэх боломжтой байсан боловч мэдэлгүй үйлдсэний улмаас хохирол, хор уршиг учирсан бол болгоомжгүй гэмт хэрэгт тооцно.”

Батбаярын хувьд хохирогчийн толгойн тус газарт архины шилээр цохисон нь гэмт санааны агуулга, чиглэл нь зориуд “хүнийг алах” зорилго, сэдэлтэй байсан гэж үзэхүйц нөхцөл байдал тогтоогдохгүй байна. Өөрөөр хэлбэл, хохирогч Тэгшээгийн амь нас хохирсон шалтгаан, үндэслэлийн хувьд нам хэмийн үйлчлэл буюу осголтоос болсон, цус алдалт нь осголт амархан явагдахад нөлөөлсөн бөгөөд шүүгдэгчийн үйлдлээс шалтгаалсан цус алдалт нь шоконд орох хэмжээний биш байсан болох нь шинжээчийн дүгнэлт, мэдүүлгээр тогтоогдож байх тул Батбаярыг хохирогчийн амь насыг хохироохыг хүссэн, уг үр дагаварт зориуд хүргэсэн гэж үзэх үндэслэлгүй.

Тодруулбал, Батбаяр, Тэгшээ нар нь хамт согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн ба хохирогчийг шөнийн цагаар зугтааж, ухамсарт ухаанаа алдаж гадаа тасарч унана, тийнхүү унаснаар осголт болно, толгойн тус газарт учирсан хөнгөн гэмтлээс шалтгаалан цус алдсан нь согтолттой хавсарч осголтод нөлөөлнө гэдгийг урьдчилан хүсэж, тооцоолон мэдсэн буюу бусдыг амь насаа алдахад зориуд хүргэсэн гэж үзэх боломжгүй юм.

Харин Батбаяр нь Тэгшээтэй харилцан маргалдаж, түүний эсрэг удаа дараа довтолж, биед нь халдсаны улмаас цус алдаж буйг, мөн согтууруулах ундааны зүйл хэрэглэсний улмаас их хэмжээний согтолтод орж биеэ хамгаалах чадвар сул байгааг мэдсэн атлаа заналхийлэх, удаа дараа халдах гэх мэтээр өөрөөс нь айж гэрээс зугтаахад хүргэсэн хууль бус үйлдлүүд хийсэн байгаа нь өөрийн үйлдлийн хууль бус шинжийг ухамсарлаж, түүний улмаас бусдын амь нас хохирох боломжтойг

урьдчилан мэдэх боломжтой байхад тус бололцоог үл хайхарч гэмт хэргийг болгоомжгүйгээр үйлдсэн гэж үзэхээр байна.

Төсөөтэй гэмт хэргээс ялган зүйлчлэх асуудал: Батбаярын үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 15.2 дугаар зүйлд заасан “Аюултай байдалд орхих, тусламж үзүүлэхгүй байх” гэмт хэргийн шинжтэй эсэхийг шалгаж үзэх нь зүйтэй байна. Хуульд уг гэмт хэргийн шинжийг “Бага насны хүүхэд, өндөр настай, хөгжлийн бэрхшээлтэй, бэртэл гэмтэлтэй, өвчний улмаас бусдын туслалцаа, асрамж шаардлагатай хүний амь нас, эрүүл мэндэд аюул учирсан нөхцөлд хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт, хэлцэл, эсхүл харилцан итгэлцлээр хүлээсэн тусламж үзүүлэх, асран хамгаалах үүргээ зориуд биелүүлээгүй орхисны улмаас хохирогчийн эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учирсан” гэж тодорхойлсон. Уг гэмт хэргийн хүндрүүлэх шинжид хохирогч нас барсан нөхцөлийг тогтоожээ.

Гэмт хэргийн объектив шинж нь гэмт этгээдийн эс үйлдэхүйгээр илрэх бөгөөд хохирогчийн амь нас, эрүүл мэндэд аюултай нөхцөл байдалд тусламж үзүүлэхээс зайлсхийж, эрүүл мэндэд нь хохирол учирснаар төгсөх материаллаг бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг юм. Гэмт эс үйлдэхүй нь эрх зүйн хэм хэмжээгээр үүссэн тусгай үүрэг, эсхүл харилцан итгэлцэлээр үүссэн ерөнхий үүрэг байж болох ба гэмт буруугийн хувьд санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ.

Бодлогын нөхцөлөөс үзэхэд Батбаяр болон Тэгшээ нар нь хамтдаа согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн, улмаар харилцан маргалдсан зэргээс тэдгээрийн хооронд үүрэг үүссэн гэж үзэх боломжгүй байх ба гэмт этгээд өөрийн хууль бус үйлдлийн үр дагаварт хайхрамжгүй хандсаны улмаас хохирогч нас барсан шалтгаант холбоотой байх тул уг гэмт хэргийн объектив болон субъектив шинжийг хангахгүй байна.

2.2 Шүүхийн хэлэлцүүлгийн явцад прокурорын биед халдсан үйлдлийн тухайд:

Уг үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Шүүгч прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчид хууль бусаар нөлөөлөх” гэмт хэргийн шинжтэй байж болох юм.

Гэмт хэргийн объектив шинж: Шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчийг хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааг эрхлэн явуулахтай холбогдуулан өөрт нь, ойр дотны хүнд нь хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлсэн, эсхүл ятгасан идэвхтэй үйлдлээр илэрнэ. Уг үйлдлийн улмаас хохирол учирсан эсэхээс үл хамаарч үйлдэл хийснээр төгсөх хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг байна.

Бодлогын нөхцөлөөс харахад Батбаяр нь шүүхийн хэлэлцүүлгийн явцад хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийн өмгөөлөгчийн хүсэлтээр шүүх хуралдааныг хойшлуулахаар шийдвэрлэсэн шүүгчийн захирамжийг уншиж сонсгох үед уг шийдвэрт бухимдаж, зүй бус үг хэллэгээр хараж, улмаар прокурорын биед халдсан нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дэг журмыг зөрчсөн, хэрэг хянан

шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгчийн биед хүч хэрэглэн халдсан идэвхтэй үйлдэл мөн.

Гэмт хэргийн субъектив шинж: Гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэх буюу Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар “өөрийн үйлдэл, эс үйлдэхүйг хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж түүнийг хүсч үйлдсэн, хохирол, хор уршигт зориуд хүргэсэн” байна.

Харин шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эрхлэн явуулахтай холбоогүйгээр хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлсэн, ятгасан бол эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг болон хүний халдашгүй чөлөөтэй байдлын эсрэг гэмт хэргээр зүйлчилнэ.

Батбаяр хэдийгээр шүүхийн хэлэлцүүлгийн явцад “миний саналыг үл хэрэгслээ” гэх шалтгаанаар прокурорын мөр рүү гараараа цохисон үйлдэл гаргасан боловч прокурорыг тухайн шүүх хуралдаанд оролцож төрийн нэрийн өмнөөс яллах чиг үүргээ хэрэгжүүлэх, мэтгэлцэх үйл ажиллагаанд нь хууль бусаар нөлөөлөх сэдэл, зорилго агуулсан гэж дүгнэх боломжгүй байна.

Түүнчлэн уг үйлдлийн улмаас прокурорын биед ямар нэгэн гэмтэл учраагүй байх тул хүний биед халдсан үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан бусад гэмт хэргийн шинжийг хангаагүй байна.

Харин энэ үйлдэл нь Зөрчлийн тухай хуулийн 15.6 дугаар зүйлд заасан “Прокурорыг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулах” зөрчлийн шинжтэй. Тодруулбал, тус хуулийн 15.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хуулиар хүлээсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь прокурорт санаатайгаар саад учруулсан, эсхүл доромжилсон, эсхүл эрх чөлөөнд нь халдсан бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор хуульчилжээ.

Батбаярын хувьд шүүх хуралдаан хойшилсон шийдвэрийг зарласны дараа саналыг нь үл хэрэгслээ хэмээн прокурорын эсрэг зүй бус үгээр доромжилж, биед нь халдан цохиж буй үйлдэл нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дэг журам, прокурорын төрийн нэрийн өмнөөс улсын яллагчаар шүүх хуралдаанд оролцох чиг үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагаанд саад учруулж буй үйлдэл гэж дүгнэхээр байна.

Явцын дүгнэлт: Батбаярын хохирогч Тэгшээгийн зүүн чамархайд архины шилээр цохиж хөнгөн хохирол учруулсан, улмаар хохирогч цус алдаж нам хэмийн үйлчлэлээр осгож нас барахад хүргэсэн үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох” гэмт хэргийн шинжийг хангаж байна. Харин шүүхийн хэлэлцүүлгийн явцад прокурорын биед халдаж, мөр хэсэгт нь гараараа 2 удаа цохисон үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжгүй ба Зөрчлийн тухай хуулийн 15.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчлийн шинжийг хангаж байна.

Гурав. Гэмт хэрэг үйлдэх үе шатыг тогтоох

Эрүүгийн эрх зүйд гэмт үйлдлийг гэмт хэрэгт бэлтгэх, завдах, төгсгөх гэсэн үе шатуудад хуваааж үздэг бөгөөд хуульд заасан тохиолдолд туйлдаа хүрч төгсөөгүй гэмт үйлдэлд ял оногдуулна. Гэмт хэрэг туйлдаа хүрч төгсөөгүй байна гэдэг нь субъект Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хангах зорилгоор тодорхой үйлдэл хийсэн боловч гаднын хүчин зүйлийн нөлөөллөөр, эсхүл өөрийн сайн дурын үндсэн дээр тухайн үйлдлээ төгсгөөгүй буюу хуульд заасан хохирол, хор уршгийг бий болгоогүй байдаг. Эрүүгийн хуулийн 2.7 дугаар зүйлд “Гэмт хэрэгт бэлтгэх”, 2.8 дугаар зүйлд “Гэмт хэрэг үйлдэхээр завдах, гэмт хэрэг үйлдэхээс татгалзах” үед ял оногдуулах журмыг тогтоосон.

Батбаярын хувьд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.6 дугаар зүйлд заасан гэмт хэргийн объектив, субъектив талын шинжийг бүрэн хангасан, гэмт үйлдлийн улмаас хохирогчийн амь нас хохирсон буюу төгссөн гэмт хэрэг байх тул уг бодлогын хүрээнд гэмт хэрэгт бэлтгэх, завдах, завдалтаас сайн дураар татгалзах үе шатуудыг шалгах шаардлагагүй байна.

Дөрөв. Гэмт хэрэгт хамтран оролцох

Гэмт хэрэг үйлдэхэд хоёр болон түүнээс дээш этгээд санаатай нэгдсэнийг гэмт хэрэгт хамтран оролцох гэнэ. Гэмт хэрэгт хамтран оролцогч нарын оролцоо буюу гэмт хэрэг үйлдэхэд гүйцэтгэсэн үүрэг, тэдгээрийн зохион байгуулалтын хэлбэрээр нь хамтран оролцох хэлбэр, төрлүүдийг тогтоож Эрүүгийн хуулийн ерөнхий ангид заасан журмын дагуу ял оногдуулна.

Бодлогод хоёр болон түүнээс дээш тооны этгээдийн үйлдэл оролцооны талаар өгөгдсөн нөхцөл байхгүй тул гэмт хэрэгт хамтран оролцох асуудлыг шалгах шаардлагагүй байна.

Тав. Гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал

Үйлдэл, эс үйлдэхүйн объектив болон субъектив шинжийн хувьд гадаад илрэх байдлаараа Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хангасан боловч Эрүүгийн хуулиар хамгаалсан нийгэм, төр, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн болон өөрийн эрх ашиг, сонирхлыг хамгаалах зорилгын үүднээс хийсэн нийгэмд ашигтай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал гэнэ. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 4 дүгээр бүлэгт аргагүй хамгаалалт; гарцаагүй байдал; баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах; албадлага, эрхшээлд автах; үндэслэл бүхий эрсдэл; тушаал даалгавар биелүүлэх гэсэн гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлын төрлүүдийг хуульчилсан.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 4.1 зүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “Өөрийн эсхүл бусдын амь нас, эрүүл мэндийн эсрэг хууль бус ба тулгарсан довтолгооны эсрэг хийсэн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй.” Хохирогч Тэгшээ нь Батбаярын гуя хэсэгт хоёр удаа өшиглөж, гутлынхаа улыг нүүрэнд нь тулгах зэргээр хууль бус үйлдэл гарган түүний биед халдсан байна. Гэвч аргагүй хамгаалалтын хүрээнд хийгдсэн үйлдлийн объектив шинжид амь нас, эрүүл мэндийн эсрэг тулгарсан бодитой довтолгоо байх, уг довтолгоо нь нэгэнт эхэлсэн, эхлэх нь тодорхой, эсхүл төгсөөгүй үргэлжилсэн байхыг шаардана. Батбаярын

хувьд хохирогч Тэгшээг орноос түлхэж, архины шилээр цохисон ба гараад зугтах үед араас нь хөөж, дахин биед нь халдаж буй зэрэг нөхцөл байдлаас үзэхэд хохирогчийн зүгээс эхлүүлсэн довтолгоо төгссөн гэж үзэхээр байх бөгөөд бодитой аюул заналхийлэл тулгарсан байсан гэж дүгнэх үндэслэлгүй байна.

Зургаа. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх, чөлөөлөх үндэслэл, журмыг тодорхойлох

Бодлогын нөхцөлд Батбаяр нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх насанд хүрсэн эсэх, хэрэг хариуцах чадвартай эсэх талаар тодорхой нөхцөл өгөгдөөгүй учир Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.2 дугаар зүйлд заасны дагуу эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрсэн, мөн хуулийн 6.3 дугаар зүйлд заасан хэрэг хариуцах чадвартай гэж дүгнэнэ.

Батбаярт холбогдох Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг нь мөн хуулийн ерөнхий ангийн 2.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар хорих ялын дээд хэмжээг таван жил, түүнээс бага хугацаагаар оногдуулахаар тогтоосон буюу хөнгөн ангиллын гэмт хэрэгт хамаарна. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 дахь заалтад зааснаар уг гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь 5 жил байна. Бодлогын нөхцөлд гэмт хэрэг 2022 оны 03 дугаар сарын 18-аас 19-нд шилжих шөнө үйлдэгдсэн талаар өгөгдсөн тул гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй.

Иймд Батбаярын үйлдсэн гэмт хэрэгт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, тэдний хувийн байдал, эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг бүх талаас нь харгалзан үзэх нийтлэг шаардлага харгалзана.

Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл бүрдсэн эсэх: Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, хөнгөрүүлэх үндэслэл, журмыг зохицуулсан. Тус зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтад зааснаар гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхөд:

- хөнгөн гэмт хэрэг үйлдсэн,
- Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй, эсхүл хорих ялын дээд хэмжээг гурван жил хүртэл, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн байх,
- гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн,
- учруулсан хохирлоо нөхөн төлсөн байхаас тухайн гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдал, мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулж гэмт хэргийг нотлоход дэмжлэг үзүүлсэн байдлыг харгалзан үзэх шалгууртай.

Бодлогод хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөс гэмт хэргийн улмаас учирсан хор уршгийн нөхөн төлбөрийг нэхэмжилсэн, үүнийг төлж барагдуулсан талаар нөхцөл өгөгдөөгүй тул төлөгдөөгүй гэж үзнэ. Түүнчлэн Батбаярын үйлдсэн гэмт

хэрэгт 1-5 жил хүртэл хорих ял оногдуулахаар заасан зэргээс эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, хөнгөрүүлэх зохицуулалтыг хэрэглэх урьдчилсан нөхцөл бүрдээгүй гэж дүгнэхээр байна.

Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх журам хэрэглэх эсэх: Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх асуудал Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 1.2, мөн 7.1 дүгээр зүйлд тус тус зохицуулагдсан ба 7.1 дүгээр зүйлд заасан зохицуулалт нь “тэнсэх” ерөнхий буюу нийтлэг журам, харин 6.7 дугаар зүйл нь тэнсэх тусгайлсан буюу нарийвчилсан зохицуулалт болно.

Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх зохицуулалтыг хэрэглэхэд гэмт хэрэг үйлдсэн этгээд нь:

- хөнгөн гэмт хэрэг үйлдсэн,
- гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн,
- 2, түүнээс дээш гэмт хэргийг санаатай үйлдээгүй байх,
- учруулсан хохирлоо нөхөн төлж хор уршгийг арилгасан, эсхүл гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөхөө илэрхийлсэн зэрэг шалгуураас гадна гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдал, мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулж гэмт хэргийг нотлоход дэмжлэг үзүүлсэн байдал зэргийг бүх талаас нь шалгаж, дүгнэх шаардлагатай.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг нь хөнгөн ангилалд хамаарах боловч өмнө дурдсанчлан Батбаяр нь хохирогчийн хууль ёсны төлөөлөгчид гэмт хэргийн улмаас учирсан хор уршгийн нөхөн төлбөрийг төлж барагдуулаагүй байх тул уг зохицуулалтын урьдчилсан нөхцөлийг хангаагүй гэж үзнэ.

Түүнчлэн Батбаярын гэмт үйлдэл, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлаас Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад заасан “хохирогчийн хууль бус, зүй бус үйлдлээс шалтгаалан гэмт хэрэг үйлдсэн” гэж үзэх хөнгөрүүлэх нөхцөл байдал тогтоогдож, 6.6 дугаар зүйлд заасан эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл тогтоогдохгүй байна.

2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр батлагдсан Өршөөл үзүүлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн 3.1.2-т зааснаар 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 24 цаг 00 минутаас өмнө үйлдэгдсэн гэмт хэргүүдэд уг хууль үйлчлэх тул Батбаярын үйлдэл нь уг хуулийн үйлчлэх цаг хугацаанд хамаарахгүй.

Долоо. Хохирол, хор уршгийн нөхөн төлбөр болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой асуудал

<u>7.1 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой асуудал:</u>

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухайн хуулийн 1.1 дүгээр зүйлд зааснаар “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино”. Үүнээс харахад эрүүгийн процессын зорилго нь зөвхөн гэмт хэрэг үйлдсэн

этгээдийн илрүүлэхээр хязгаарлагдахгүй, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хууль дээдлэх зарчмыг хангахад давхар чиглэнэ.

Хэрэв нотлох баримт хууль ёсны шаардлагыг хангаагүй бол түүний агуулгаас үл хамааран түүнийг нотлох баримтаар үнэлэх боломжгүй.

Биологийн дээж авах ажиллагаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтын эх сурвалжийг бүрдүүлэхэд чиглэсэн, хуульд нарийвчлан журамласан онцгой ажиллагаа бөгөөд уг ажиллагааг хуульд заасан журмыг зөрчиж явуулсан тохиолдолд түүнд үндэслэн гаргасан шинжээчийн дүгнэлт нотлох баримтын ач холбогдолгүй болох эрх зүйн үр дагавар үүсдэг болно.

Дээрх нөхцөлөөс дүгнэхэд Батбаяр согтуурлаа шалгуулахаас татгалзаж, өөрийн хүсэлтээр биологийн дээж өгөхөөр болсон нөхцөл байдалд цагдаагийн байгууллагын ажилтан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн захирамжилсан /императив/ хэм хэмжээг зөрчсөн байна.

Тодруулбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар мөрдөн шалгах ажиллагаа, прокурорын хянан шалгах ажиллагаа, шүүх хуралдааны тэмдэглэл, түүнд хавсаргасан дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, авсан гэрэл зураг, үйлдсэн гар зураг, ул мөрөөс авсан хэв нотлох баримт болох ба мөн хуулийн 16.14 дүгээр зүйлд зааснаар мөрдөгч мөрдөн шалгах ажиллагаа явуулах замаар нотлох баримтыг цуглуулж тэмдэглэлд тусгаж бэхжүүлнэ. Иймд эрүүгийн хэрэгт явуулсан мөрдөн шалгах ажиллагааны илрэх хэлбэр нь тэмдэглэл байх бөгөөд түүнд тусгагдсан ажиллагаа хууль ёсны дагуу явагдсан эсэхийг тэмдэглэлд тусгагдах шаардлагатай мэдээллүүд бүрэн гүйцэд тусгагдсан эсэхээр шалгаж үнэлнэ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 28.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт мөрдөгч мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэл үйлдэхэд тавигдах шаардлагуудыг тусгасан. Үүнд ажиллагааг хойшлуулшгүй тохиолдолд явуулж байгаа бол үндэслэл бүхий нөхцөл байдлын талаар, ажиллагаанд оролцсон, байлцсан хүний талаар мэдээлэл, эрх, үүрэг танилцуулсан тухай болон ажиллагаа явуулах үндэслэл зэргийг бүхэлд нь тодорхой тусгах хуулийн шаардлагуудыг тавьжээ.

Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22.4 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт зааснаар мөрдөгч хойшлуулшгүй тохиолдолд хүний биеэс шинжилгээнд зориулж биологийн дээж авах мөрдөн шалгах ажиллагааг прокурорын зөвшөөрөлгүй явуулж болох эрхтэй хэдий ч прокурорт даруй мэдэгдэж, ажиллагаа дууссанаас хойш 24 цагийн дотор тухайн ажиллагааг хүчинтэйд тооцуулахаар зөвшөөрөлгүй явуулах болсон үндэслэлийг нотлох баримт, тайлбарыг прокурорт бичгээр хүргүүлэх ерөнхий журмыг хуульчилжээ.

Прокурор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар мөрдөгчийн баримт, тайлбарыг хүлээн авснаас хойш 24 цагийн дотор мөрдөн шалгах ажиллагааг хүчинтэйд тооцох эсэхийг шийдвэрлэдэг.

Цагдаагийн байгууллагын ажилтан зөвшөөрснөөс бусдыг хориглох, процессын хэм хэмжээг чанд сахих үүрэгтэй. Гэтэл бодлогын нөхцөлөөс үзэхэд мөрдөгч Батбаярын сайн дураар өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр биологийн дээж

авах ажиллагааг явуулсан боловч энэ талаар тэмдэглэлд бүрэн тусгаагүйн дээр хойшлуулшгүй тохиолдолд прокурорын зөвшөөрөлгүй явуулсан ажиллагаанд нөхөн зөвшөөрөл аваагүй зэрэг нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг зөрчсөн үндэслэлд хамаарна.

7.2 Хохирол, хор уршгийг нөхөн төлөхтэй холбоотой асуудал:

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “Энэ хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учруулсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.” Батбаярын үйлдлийн улмаас хохирогч Тэгшээгийн амь нас хохирсон бөгөөд хүний амьд явах эрхэд халдсан үйлдлийн үр дагаврыг бусад хэлбэрээр нөхөн төлөх, урьдын байдалд сэргээн тогтоох талаар ойлголт байх бололцоогүй тул уг гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх бодит боломжгүй.

Харин мөн зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар гэмт хэрэг үйлдэж хохирол учруулсны улмаас үүссэн үр дагаврыг гэмт хэргийн хор уршигт тооцно. Иргэний хуулийн 508 дугаар зүйлд “Хохирогч нас барснаас учирсан гэм хорыг арилгах” зохицуулалтыг хуульчилжээ.

Уг зохицуулалтын дагуу хохирогч нас барсан бол түүнийг оршуулахтай холбогдсон зайлшгүй зардлыг шаардах эрхтэй. Харин гэмт хэргийн улмаас нас барсан иргэний хамт амьдарч байсан гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, эсхүл насанд хүрээгүй гишүүний хууль ёсны төлөөлөгчөөр томилогдсон этгээд нь өөрийн сэтгэцэд учирсан гэм хорыг арилгуулахаар шаардах эрхийг Иргэний хуулийн 508 дугаар зүйлийн 508.5 дахь хэсэгт 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд уг хуулийг дагаж мөрдөх хугацааг хууль тогтоогчоос 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрөөс Шүүх шинжилгээний тухай хууль болон дагалдах бусад хуулийн хамт хүчин төгөлдөр дагаж мөрдөхөөр хоёрдмол утгагүй тогтоосон. Иргэний хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт иргэний хууль тогтоомжийг хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд буцаан хэрэглэхгүй тул үүнээс өмнө үйлдэгдсэн гэмт хэргүүдэд иргэний хуулийн уг зохицуулалтыг буцаан хэрэглэх боломжгүй юм.

Түүнчлэн амь хохирогч Тэгшээгийн хууль ёсны төлөөлөгчөөс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өмгөөлөгчөөс авсан эрх зүйн туслалцааны хөлсийг нэхэмжилсэн байх боловч уг зардлыг эрүүгийн хэргийн улмаас учирсан хохирол, хор уршигт тооцох үндэслэлгүй. Харин Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 161 дугаартай “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг тооцох, санхүүжүүлэх журам”-д зааснаар дараах зардлуудыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардалд тооцон буруутай этгээдээр гаргуулна. Үүнд журмын 2.6 дугаар зүйлийн 2.6.6-д зааснаар насанд хүрээгүй, төлбөрийн чадваргүй хохирогч, гэрчийн өмгөөлөгчийн өмгөөллийн үйлчилгээний хөлсийг хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээнд заасан хэмжээгээр гэжээ. Хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөс төлбөрийн чадваргүй эсэх талаар баримтыг шүүхэд ирүүлээгүй тул түүнийг төлбөрийн

чадвартай гэж үзэх ба өмгөөллийн хөлсийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардалд тооцох боломжгүй байна.

Дээрхээс дүгнэхэд амь хохирогч Тэгшээгийн хууль ёсны төлөөлөгчөөс оршуулгын зардалд нэхэмжилсэн 30,000,000 төгрөгийг Иргэний хуулийн 508 дугаар зүйлийн 508.1 дэх хэсэгт зааснаар Батбаяраас гаргуулах үндэслэлтэй боловч сэтгэцэд учирсан хор уршгийн нөхөн төлбөр болон өмгөөлөгчийн хөлсийг тус тус гаргуулахгүй.

Нэгдсэн дүгнэлт

Батбаяр нь хохирогч Тэгшээгийн зүүн чамархай хэсэгт архины шилээр цохиж хөнгөн гэмтэл учруулах, удаа дараагийн үйлдлээр цохих зэргээр үргэлжилсэн хадлагаас шалтгаалан түүнийг гэрээсээ зугтааж шөнийн цагаар осгож нас барахад хүргэсэн нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох” гэмт хэргийн шинжийг хангажээ. Анхан шатны шүүхийн хэлэлцүүлгийн явцад зүй бус үг хэллэг ашигласан, прокурорын биед халдсан үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжгүй. Харин Зөрчлийн тухай хуулийн 15.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Прокурорыг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулах” зөрчлийн шинжтэй байна.

Хэдийгээр хохирогч түрүүлж өшиглөх, гутлын улыг нүүрэнд нь наах зэргээр зүй бус үйлдэл гаргасан байх боловч гэмт үйлдэл үргэлжилсэн байдал, бодлогын нөхцөлөөс харахад Батбаярын үйлдлийг тулгарсан довтолгооны эсрэг хийсэн аргагүй хамгаалалтын шинжтэй үйлдэл гэж дүгнэх боломжгүй юм.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Батбаярын үйлдсэн хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй, түүнийг тэнсэх, эрүүгийн хариуцлагаас хөнгөрүүлэх, чөлөөлөх үндэслэлгүй байна. Харин Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад зааснаар уг гэмт хэрэг гарахад хохирогчийн зүй бус үйлдэл нөлөөлсөн гэж үзэх эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдал тогтоогдсон ба гэмт хэрэг гарсан цаг хугацаа нь 2021 оны Өршөөл үзүүлэх тухай хуулийн үйлчлэлд хамаарахгүй байх тул түүнд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан нийтлэг шаардлагыг харгалзан үзэж тохирох ялыг оногдуулна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөс тавьсан хүсэлтийн тухайд амь хохирогч Тэгшээгийн хууль ёсны төлөөлөгчөөс оршуулгын зардалд нэхэмжилсэн 30,000,000 төгрөгийг Иргэний хуулийн 508 дугаар зүйлийн 508.1 дэх хэсэгт зааснаар Батбаяраас гаргуулах үндэслэлтэй боловч сэтгэцэд учирсан хор уршгийн нөхөн төлбөр болон өмгөөлөгчийн хөлсийг тус тус гаргуулах боломжгүй. Мөн Батбаярын биеэс биологийн дээж авах ажиллагаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан нотлох баримтад тавигдах шаардлагыг зөрчсөн байх тул уг асуудлаар гаргасан өмгөөлөгчийн хүсэлтийг хүлээж авах үндэслэлтэй байна.

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН БОДЛОГО ОНООНЫ ХУВААРИЛАЛТ

Д/д	**Шалгаж, үндэслэл бүхий дүгнэлт хийх үндсэн асуудлууд**	**Өгвөл зохих оноо**
1	Гэмт хэргийн шинжийг тодорхойлж, зүйлчлэл хийсэн хууль зүйн дүгнэлт, хууль хэрэглээ	0-10
2	Гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал болон эрүүгийн хариуцлага хүлээлгэх нийтлэг үндэслэл, журмыг хэрэглэх талаарх дүгнэлт, хууль хэрэглээ	0-5
3	Хохирол, хор уршиг, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой асуудал шийдвэрлэх	0-3
4	1-3 дугаарт зааснаас бусад бодлого бодох аргачлал, алхмын хүрээнд хийсэн дүгнэлт, хууль хэрэглээ	0-2
Нийт оноо		**20**

---ooOoo---